



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 20/1

Арвайхээр сум

Г

Журам батлах тухай

Г

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйл, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 31, 32, 33 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архины хамааралтай, архинд донтох эмгэгтэй иргэдтэй ажиллах чиг үүрэг бүхий Мэргэжлийн баг, Аддиктологийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга наарт, багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, хяналтын хэлтэст үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09, 2017 оны 26 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА О.ПУРЭВДОРЖ



622301103



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн  
дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

## МЭРГЭЖЛИЙН БОЛОН АДДИКТОЛОГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### Нэг. Мэргэжлийн баг

Ажлын хэсгийн дарга:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга \
- 

Нарийн бичгийн дарга:

- Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
- Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн
- Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэтгэц наркологийн тасгийн эмч
- Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч
- Ариусахуйн үндэс төрийн бус байгууллага

### Хоёр. Аддиктологийн баг

Ажлын хэсгийн ахлагч: Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга: Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

- Сумын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
- Сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн
- Сум дундын цагдаагийн тасгийн, хэсгийн төлөөлөгч
- Сумын Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан
- Сумын Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
20/дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

## МЭРГЭЖЛИЙН БОЛОН АДИКТОЛОГИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл:

Энэхүү журмын зорилго нь аймаг, сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, архинд донтох эмгэгтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, түүнчлэн гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор тэднийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах арга хэмжээг авах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бусад нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, өөртөө туслах бүлгийн хамтарсан Мэргэжлийн болон Аддиктологийн багуудын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд оршино.

### Хоёр. Зарчим

2.1 Мэргэжлийн болон аддиктологийн баг нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт, энэхүү журмыг үйл ажиллагаандaa удирдлага болгон дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- 2.1.1 Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- 2.1.2 Хувь хүний нууцыг чандлан хадгалах;
- 2.1.3 Улс төрөөс ангид байх;
- 2.1.4 Багаар ажиллах.

### Гурав. Мэргэжлийн болон аддиктологийн багуудын үйл ажиллагааны чиглэл

3.1. Мэргэжлийн баг нь сумдын аддиктологийн багийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1 Багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг чиг үүргийн хүрээнд гарган сумын ГХУСАЗСЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах;

3.1.2 Багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлэх;

3.1.3 Архины хамааралтай, архинд донтох эмгэгтэй иргэдийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх;

3.1.4 Мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд илгээж, архинд донтох эмгэгтэй эсэх дүгнэлт гаргуулж, архинд донтох өвчтөнийг эдгэрүүлэх "Миннесота" загварын эмчилгээнд хамруулах;

3.1.5 Архинаас татгалзсан, сайн дурын болон албадан эмчилгээнд хамрагдаж үр дүнд хүрсэн иргэнийг нийгэмшүүлэх, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах;

3.1.6 Архинд донтох эмгэгтэй, архины хамааралтай иргэдэд болон түүний ар эрийнхэнд тогтмол сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сургалт сурталчилгаа явуулах;

- 3.1.7 Олон нийтэд архи, согтууруулах ундааны хор уршгийн талаар ойлгуулах зорилгоор контент, сургалт нөлөөллийн ажил явуулах;
- 3.1.8 Өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах;
- 3.1.9 Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулсан байгууллага хамт олны үйл ажиллагааг, түүнчлэн архинаас татгалзсан иргэнийг зөвшөөрсөн тохиолдолд түүний тухай олон нийтэд сурталчлах;
- 3.1.10 Үйл ажиллагааны хүрээнд төр болон төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 3.1.11. Үйл ажиллагаандыа иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх;
- 3.1.12 Мэргэжлийн багаас өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- 3.1.13 Зохион байгуулсан үйл ажиллагааны талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байх;
- 3.1.14 Багийн үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, тулгамдсан асуудлыг мэргэжлийн багт, түүнчлэн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хандан танилцуулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

3.2. Аддиктологийн баг нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр суманд ажиллах бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.2.1 Багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг чиг үүргийн хүрээнд гарган аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах;
- 3.2.2. Багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
- 3.2.3. Архи согтууруулах ундааны хэрэглээг тогтоох судалгааг орон нутагтаа хийж, нотолгоонд сууринсан арга хэмжээг зохион байгуулах;
- 3.2.4. Мэргэжлийн болон аддиктологийн багийн гишүүдийг сургаж, чадавхжуулах туршлага судлуулах ажлыг зохион байгуулах;
- 3.2.5. Аддиктологийн багийг мэргэжил, арга зүйгээр хангах, хамтран ажиллах
- 3.2.6. Аддиктологийн багийн ажлын мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр авч, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- 3.2.7. Үр дүнтэй ажилласан баг, алба хаагчийг шагнаж урамшуулах саналыг танилцуулах;
- 3.2.8 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн наркологийн тасгийг өргөжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах талаар орон нутгийн удирдлагууд болон мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;
- 3.2.9 Үйл ажиллагааны хүрээнд төр болон төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

### **Дөрөв. Багуудын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх**

- 4.1 Мэргэжлийн баг, аддиктологийн багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор жил бүр үйл ажиллагааг дүгнэж, урамшуулалт олгоно.
- 4.2 Аддиктологийн баг нь ажлын төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Мэргэжлийн багт цаасаар болон цахимаар хүргүүлнэ.
- 4.3 Мэргэжлийн баг нь сумдын аддиктологийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор хуралдаанаараа хэлэлцэн энэхүү журмын 4.4-т заасны дагуу дүгнэж, танилцуулга материалыг өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хамт аймгийн ГХУСАЗСЗөвлөлд хүргүүлнэ.
- 4.4 Мэргэжлийн болон аддиктологийн багийн төлөвлөгөөний биелэлтийг

дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- а/90-100 оноо авсан бол А үнэлгээ (маш сайн)
- б/ 80-89 оноо авсан бол В үнэлгээ (сайн)
- в/ 70-79 оноо авсан бол С үнэлгээ (хангалттай)
- г/ 50-69 оноо авсан бол D үнэлгээ (дутагдалтай)
- д/ 50-аас доош оноо авсан бол F үнэлгээ (хангалтгүй)

4.5 Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь,

1/ Мэргэжлийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг сумдын аддиктологийн багуудын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн дунджид харьцуулсан дүнгээр “маш сайн” гэж дүгнэгдсэн бол 1,0 сая төгрөг, “сайн” гэж дүгнэгдсэн бол 500,0 төгрөгийн урамшуулалт олгох тухай, “дутагдалтай”, “хангалтгүй” гэж дүгнэгдсэн бол үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай;

2/ Аддиктологийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтээр “маш сайн” болон “сайн” гэж дүгнэгдсэн багуудаас хамгийн өндөр оноо авсан эхний 1 багт 700,0 төгрөгийн урамшуулалт олгох тухай, “дутагдалтай”, “хангалтгүй” гэж дүгнэгдсэн багуудад үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай шийдвэрийг тус тус гаргана.

4.6 Урамшуулалт шаардагдах хөрөнгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсөвт жил бүр тусгана.

#### **Тав. Бусад**

5.1 Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

\_\_\_\_oOo\_\_\_\_\_